

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 7508 дугаарт бүртгэв.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар А/616, А/480

Дархан-Уул аймаг

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ШОШГО, АНХААРУУЛГЫН ЗАГВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Согтууруулах ундааны шошгод тавигдах шаардлага”-ыг нэгдүгээр, “Анхааруулгын загварт тавигдах шаардлага”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Довчинсүрэн), Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоодын аудитын газар (Б.Батшагай), Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаад)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү тушаалыг бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтэст үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД

М.БАДАМСҮРЭН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Ж.ЧИНБҮРЭН

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын
хамтарсан 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/616, А/480
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ШОШГОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.Монгол Улсад үйлдвэрлэсэн, савласан болон импортолсон согтууруулах ундааны шошго нь Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан болон дараах нэмэлт мэдээллийг агуулсан байна. Үүнд:

1.1.согтууруулах ундааны нэр төрөл, цувралын дугаар, зураасан код;

1.2.согтууруулах ундаа үйлдвэрлэгч, экспортлогч, импортлогч улс орон, компанийн нэр, хаяг;

1.3.савлалтын хэмжээ;

1.4.орц бүрдүүлэгч, хүнсний нэмэлтийн дугаар, тэмдэглэгээ, илчлэг, тэжээллэг чанарын мэдээлэл;

1.5.үйлдвэрлэсэн он, сар, өдөр, хадгалах нөхцөл, хугацаа;

1.6.согтууруулах ундааны хатуулаг буюу этилийн спиртийн эзлэх хувь;

1.7.стандартын тэмдэглэгээ;

1.8.согтууруулах ундааны хэрэглээнээс үүдэлтэй эрүүл мэндийн сөрөг нөлөөллийн анхааруулга;

1.9.хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх нууцлалын тэмдэглэгээ.

2.Анхааруулгын загвар нь тэмдэглэгээ, анхааруулга, сэрэмжлүүлгээс бүрдэнэ.

3.Шошгод агуулагдах нэмэлт мэдээллийг Монгол Улсын техникийн зохицуулалт, стандартаар зохицуулна.

4.Согтууруулах ундааны шошго, савлагааны мэдээллийн үнэн зөв, энэхүү шаардлагад нийцүүлсэн байдлыг тухайн үйлдвэрлэгч, экспортлогч, импортлогч хуулийн этгээд хариуцна.

5.Согтууруулах ундааны шошгод далд хэлбэрээр бараа бүтээгдэхүүний сурталчилгаа байршуулах, бусад согтууруулах ундаатай харьцуулахад хор нөлөө багатай гэсэн утга бүхий үг бичих, хэрэглэгчийг төөрөгдүүлэх зорилго бүхий үг хэрэглэх буюу түүнтэй адилтгах лого, брэндийн дүрс, тэмдэг, өнгө, тэдгээрийн хослол хэрэглэхийг хориглоно.

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын
хамтарсан 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/616, А/480
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ АНХААРУУЛГЫН ЗАГВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Согтууруулах ундааны эрүүл мэндийн анхааруулгын загварт тавигдах шаардлага нь Монгол Улсад согтууруулах ундаа үйлдвэрлэгч, импортлогч хуулийн этгээд бүтээгдэхүүний шошгод байршуулах эрүүл мэндийн анхааруулгын хэм хэмжээг тогтоох зорилготой.

2.Энэхүү шаардлагаар согтууруулах ундааны шошгод байрлуулах анхааруулгын агуулга, байршил, хэлбэр, хэмжээ, дүрслэлийг тодорхойлох юм.

Хоёр.Ерөнхий шаардлага

2.1.Шошгон дээрх бичвэр нь Монгол хэлээр эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн, бүрэн гүйцэт, үнэн зөв байх.

2.2.Шошгын нийт талбайн 20%-иас доошгүй зай, талбайд мэдээллийг байршуулах.

2.3.Шошгын бичвэрт анхааруулгыг тод өнгө, харагдахуйц үсгийн фонтоор бичих.

2.4.Шошгын бичвэрийн агуулга нь тодорхой, нэг мөр ойлгогдох утга санаатай, ойлгомжтой үг хэллэг бүхий өгүүлбэртэй, техникийн бус хэллэгтэй байх.

2.5.Шошго нь олон улсад ойлгогдохуйц, тэмдэглэгээтэй байх.

Гурав.Бичвэрийн агуулгын шаардлага

Эрүүл мэндийн мэдэгдлийн чиглэлээр дор дурдсан гурван агуулгын аль нэг агуулгыг шошгод тусгасан байх шаардлагатай. Үүнд:

3.1.Эрүүл мэндэд учрах эрсдэл

- Хэтрүүлэн хэрэглэх нь таны тархи, зүрх, элгэнд сөргөөр нөлөөлнө;
- Согтууруулах ундаа нь донтох аюултай.

3.2.Онцгой бүлэгт зориулсан хориг

- Жирэмсэн үед согтууруулах ундаа хэрэглэх нь урагт хортой;
- Хүүхэд, өсвөр насанд согтууруулах ундаа хэрэглэх нь сөрөг нөлөөтэй.

3.3.Зан үйл, аюулгүй байдал

- Согтууруулах ундаа хэрэглэсэн үед жолоо барихыг хориглоно;
- Архидан согтуурах нь амь насанд аюултай;
- Хэтрүүлэн хэрэглэх нь гэмт хэрэг, хүчирхийллийг бий болгож, архинаас хамааралтай эмгэг үүсгэнэ.

Дөрөв.Тэмдэглэгээ ашиглах шаардлага

Анхааруулгад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон доорх тэмдэглэгээг байршуулна. Үүнд:

4.1. 21 нас хүрээгүй хүн хэрэглэхийг хориглоно.

4.2.Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд хэрэглэхийг хориглоно.

4.3.Тээврийн хэрэгсэл жолоодож байгаа хүн хэрэглэхийг хориглоно.

Зурган тэмдэглэгээ:

Заалт 4.1	Заалт 4.2	Заалт 4.3
		

Тав.Байршил ба бичиглэлийн шаардлага

5.1.Шошгыг согтууруулах ундааны савны нүүрэн талд нүдэнд хамгийн тод харагдах хэсэгт байрлуулна.

5.2.Шошго дээрх бичвэрийг бусад мэдээлэлтэй харьцуулбал үсгийн “14-20” хэмжээгээр, arial font, bold хэлбэрээр бүх үсгийг томоор (capital letter), ирмэг дагуу 1 мм-ээс багагүй өргөн хүрээтэй хэвлэнэ.

5.3.Шошго дээрх өнгө нь дэвсгэр өнгөнөөс ялгарах, тод харагдахуйц өнгөний ялгарал сайтай хэвлэгдсэн байх (жишээ: цагаан дэвсгэр дээр хар үсэг).

5.4.Шошгын нийт талбайн 20%-иас доошгүй зай, талбайд мэдээллийг байршуулна.

Зургаа.Бусад шаардлага

6.1.Бүтээгдэхүүний сав, баглаа боодол гэмтсэн, битүүмжлэл алдагдсан тохиолдолд хэрэглэхийг хориглоно.

6.2.Бусдыг согтууруулах ундаа хэрэглэхийг, шаардахыг хориглоно.

6.3.Бүтээгдэхүүний найрлагад орсон түүхий эдэд хэт мэдрэг хүмүүс анхаарна уу.

Долоо.Хариуцлага

7.1.Энэхүү шаардлагыг зөрчсөн хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 7509 дүгээрт бүртгэв.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 7/20

Баянхошуу

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Малчин өрх, мал бүхий этгээдийн малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг тэмээнд 0 төгрөг, адуунд 400 төгрөг, үхэрт 400 төгрөг, хонинд 300 төгрөг, ямаанд 500 төгрөг байхаар тус тус баталсугай.

2.Малын тоо толгойн албан татварыг хуульд заасан хугацаанд орон нутгийн төсөвт төвлөрүүлж, хуульд заасан үйл ажиллагаанд зарцуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Л.Батсайхан)-д даалгасугай.

3.Хууль зүйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад холбогдох бичиг баримтын хамтаар хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга (О.Амарзаяа), Татварын Улсын байцаагч (М.Мандах) нарт даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03/03, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 7073 дугаарт бүртгэгдсэн бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МӨНХЖАРГАЛ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ШАРГА СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 32

Баянгол

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын хураамжийг төсөвт төвлөрүүлж, хог хаягдлын үйлчилгээг сайжруулж, ажиллахыг сумын Засаг дарга (Д.Батцагаан)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг захиргааны хэм хэмжээний актаар бүртгэгдсэн өдрөөс эхлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Х.ТӨРТУЛГА

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
32 дугаар тогтоолын хавсралт*

**ШАРГА СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН
ХЭМЖЭЭ**

№	Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөгч, ногдох эх үүсвэр	Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөх хугацаа	Хураамжийн хэмжээ (төгрөг)	Тайлбар
1.	Айл өрх	сард	1250	Ахуйн хог хаягдлын хураамж
3.	Аж ахуйн нэгж	сард	5000	
4.	Төсөвт байгууллага	сард	5000	
5.	Нэгдсэн халаалтын уурын зуух	сард	10000	
6.	Шатахуун түгээх станц	сард	10000	

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 7511 дүгээрт бүртгэв.

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ШАРГА СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 33

Баянгол

**МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ
ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.15 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

- 1.Тус сумын малын тоо толгойн албан татварын хэмжээг малын төрөл тус бүрээр тогтоож, хавсралтаар баталсугай.
- 2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (Н.Нарантуяа)-д даалгасугай.
- 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулж, сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Х.ТӨРТУЛГА

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралын
2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
33 дугаар тогтоолын хавсралт*

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

Д/д	Малын төрөл	Татварын хэмжээ /төгрөгөөр/
1	Адуу	300
2	Тэмээ	300
3	Үхэр	300
4	Хонь	300
5	Ямаа	300

СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 04

Баясгалант

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын хэмжээнд 2024 оны өвөлжилт хүндэрч зуд болсны улмаас мал сүрэг их хэмжээгээр хорогдсон, малчдын амьжиргааны түвшин буурсан тул малын тоо толгойн албан татварын хэмжээг төрөл тус бүрээр 0 (тэг) төгрөг байхаар тогтоосугай.

2.Хуулийн хэрэгжилтийг хангуулан өмнөх онуудын орлогыг төсөвт төвлөрүүлэн зориулалтын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга (А.Батдэлгэр)-т үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

ДАРГА

М.САЙНХҮҮ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 7513 дугаарт бүртгэв.

СҮХБААТАР АЙМГИЙН АСГАТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 07

Улаан дэл

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 9 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Малын тоо толгойн албан татварын хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахын Асгат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Соёл-Эрдэнэ), Асгат сумын засаг дарга (У.Мөнхбаяр) нарт үүрэг болгосугай.

3.Батлагдаж гарсан тогтоолыг “Хууль зүйн дотоод хэргийн яам”-нд хянуулж улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ОТГОНЗАЯА

*Сүхбаатар аймгийн Асгат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 07 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт*

Д/д	Малын төрөл	Ногдох албан татвар
1	Адуу	1000
2	Үхэр	0
3	Тэмээ	0
4	Хонь	0
5	Ямаа	500

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 7514 дүгээрт бүртгэв.

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 07

Лүн-Уул

ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, 64.5, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит 09 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөгдөх “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг 01 дүгээр хавсралтаар батапсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамж, нэгжийн үнэ тарифыг мөрдөж, албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдэд дагаж мөрдүүлэн, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж хагас, бүтэн жилээр Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга (Б.Наранбат)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хорооны дарга, гишүүдэд даалгасугай.

4.Тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгтсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа дагаж мөрдсүгэй.

5.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 06 дугаар тогтоолыг хүчингүйд болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.МАНАЛЖАВ

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
09 дүгээр хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 18-ны
өдрийн 07 тоот тогтоолын 01 дүгээр хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ

№	Ангилал	Төлбөр ноогдуулах хугацаа, нэгж	Төлбөрийн хэмжээ/төгрөг/
1	Айл өрх/ иргэн	Сард	500
2	Төсөвт байгууллага	Сард	20000
3	Уул уурхайн ААН	Сард	1000000
4	Уурын зуухны үнс	Сард	250000
5	Махны үйлдвэр, мал нядалгаа	Сард	1200000
6	Түүхий эд авдаг цэг	Сард	100000
7	ААН-байгууллага байнгын үйл ажиллагаа явуулдаг/ цахилгаан, шатахуун түгээх станц, .банк/	Сард	40000
8	Газар тариалан эрхлэгч аж ахуй нэгж	Сард	50000
9	Газар тариалан эрхлэгч иргэн	Сард	40000

Тайлбар:

1.Улирлын шинжтэй ажилладаг төсөвт байгууллага аж ахуй нэгж хог хаягдлын хурааамжийг ажиллаж байх хугацаандаа төлнө.

2.Худалдаа үйлчилгээний газар, аж ахуй нэгж, төсөвт байгууллагууд жилийн эхэнд сумын Засаг даргатай гэрээ байгууллана.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 7515 дугаарт бүртгэв.

ОРХОН АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 10

Орхон

ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3. дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Орхон аймгийн зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Орхон аймгийн Жаргалант сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орхон аймгийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн (Ч.Мөнхзул)-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Орхон аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн “Тариф батлах тухай” 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн дугаар 05 тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Орхон аймгийн зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн (Ч.Мөнхзул)-д даалгасугай.

ДАРГА

Ч.МӨНХЗУЛ

ГИШҮҮН

М.АНХБАЯР

ГИШҮҮН

Г.ТУЛГАБААТАР

Орхон аймгийн зохицуулах зөвлөлийн
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
10 дугаар тогтоолын хавсралт

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

1.Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф / НӨАТ-гүй /
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын дулаан	Халаалт	төг/м3	2,850.0
		Халаалт, хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/ГЖ	16,672.0
2	Хэрэгцээний ус халаасан дулаан		төг/м3	3,850.0

2.Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал			Хэмжих нэгж	Тариф / НӨАТ-гүй/
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0”-ын өрөөний халаалт хамаарна)			Төг/м2	1,000.0
				Төг/ГЖ	12,170.0
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	3,850.0
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	5,612.0
		Усны зарцуулалтаар		Төг/м3	3,850.0
		Хэмжүүрээр		Төг/ГЖ	12,170.0
3	Дулааны үйлчилгээний тариф	40 м2 хүртэл талбайтай айл өрх		Төг/сар	6,600.0
		41 м2-аас 80 м2 хүртэл талбайтай айл өрх		Төг/сар	11,000.0
		81 м2-аас дээш талбайтай айл өрх		Төг/сар	22,000.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 7516 дугаарт бүртгэв.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 26

Ханх сум

ХОГ ХАЯГДЛЫН ТАРИФ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 62 дугаар зүйлийн 62.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, Сангийн сайд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Хураамжийг батлагдсан үнэ, тарифын дагуу иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэр, үйлчилгээний газруудаас хураан барагдуулж орон нутгийн төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлж хагас бүтэн жилээр биелэлт үр дүнг нь танилцуулж ажиллахыг сумын Татвар хураагч (Ч.Дэлгэрмаа)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн 21 дүгээр тогтоол хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Б.Уянга)-д даалгасугай.

ДАРГА

Л.ДУЛАМХҮҮ

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит
V хуралдааны 26 дугаар тогтоолын хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

Д/д	Үйлчилгээний төрлүүд	Хэмжих нэгж	Хураамж /төгрөг/
Хог хаягдлын үйлчилгээний хураамж			
1	Төвийн багийн иргэн	Сард	850
2	Хөдөөгийн багийн иргэн	Сард	450
3	Жуулчны бааз, амралтын газар	Сард	10000
4	Худалдаа, үйлчилгээний газар	Сард	13000
5	Хөрөө рам, модон эдлэлийн үйлдвэр	Сард	10000
6	Сумын төвд болон төв суурин газрын ойролцоо бүсэд байгаа мал бүхий өрх	Сард	3000
7	Ресторан, кафе, хоолны газар	Сард	12000
8	Ил задгай худалдаа үйлчилгээ эрхлэгч дэлгүүр, Баяр наадмын талбайн цайны газар, бусад цэгүүд	Ажиллах хугацаанд сард	10000
9	Төв суурин газар мал нядалгаа хийсэн иргэн, хуулийн этгээд	Сард	23000

БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар VIII/03

Дархан баг

2026 ОНЫ АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТЭГЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.6 дахь заалтыг, тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэгхангай сумын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал эрсдэлтэй түвшинд хүрсэн, өвс тэжээл-шатахууны хомсдол, үнийн өсөлтөөс малчдын өрхийн бодит орлого буурах нөхцөл байдал үүсэж малчдын амьжиргааг дэмжих, мал аж ахуйн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор 2026 оны малын тоо толгойн албан татварын хэмжээг малыг төрөл тус бүрээр 0 (тэг) төгрөгөөр тогтоосугай.

2.Тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх арга хэмжээг авч ажиллахыг сумын Татварын улсын байцаагч Б.Должинням, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (И.Ичинхорлоо) нарт тус тус даалгасугай.

3.Тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг сумын Засаг дарга (Э.Эрдэнэбулган)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн III/03 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Н.ЭРХЭМБАЯР

ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 30

Тавин

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.16, 22 дугаар зүйлийн 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан тарифын дагуу аж ахуйн нэгж, албан байгууллага, айл өрхүүдэд дагаж мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ю.ТУЯАМАА

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
30 дугаар тогтоолын хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Хог хаягдлын нормативын ангилал		Хэмжих нэгж	Нэгжээс авах хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
1	Айл өрх	Сумын төвийн өрх		Сард 1000
2		Малчин өрх		Сард 2000
3		Сумын төвд малаа малладаг өрх	50 хүртэл хонин толгой	Сард 3000
4			50-100 хүртэл хонин толгой	Сард 5000
5			101-200 хүртэл хонин толгой	Сард 7000
6			201-ээс дээш хүртэл хонин толгой	Сард 9000
7	Зочид буудал, амралтын газар, жуулчны бааз			Сард 1500
8	Хүүхдийн цэцэрлэг, ясли			Сард 10800
9	Ерөнхий боловсролын сургууль			Сард 25000
10	Албан байгууллага, ААН, Банкууд			Сард 10000
11	Соёлын төв			Сард 12000
12	Эрүүл мэндийн байгууллага			Сард 10000
13	Уурын зуух			Сард 300000
14	Эмийн сан			Сард 20000
15	Худалдааны төв, хүнсний дэлгүүр, зах , супер маркет			Сард 20000
16	ШТС			Сард 10000
17	Авто засвар, дугуй засвар			Сард 10000
18	Үсчин, салон , гоо сайхан, оёдол, халуун ус			Сард 10000
19	Ресторан, бар, кафе, цайны газар			Сард 20000
20	Уул уурхайн хог хаягдал			Сард 300000

ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 31

Тавин

ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФЫГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.16, 22 дугаар зүйлийн 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг шинэчлэн тогтоож хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний хураамжийг тарифын дагуу аж ахуйн нэгж, албан байгууллага, айл өрхүүдэд мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ю.ТУЯАМАА

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн
31 дүгээр тогтоолын хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Хог зөөврийн ачилтын нормативын ангилал	Хэмжих нэгж	Хураамжийн хэмжээ сард (төгрөгөөр)
1.	Айл өрх	1 өрх	10000
2.	Албан байгууллага, аж ахуйн нэгж	1 байгууллага	20000

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 31

Тайгам

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ БОЛОН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын хэмжээнд энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг нэгдүгээр хавсралтаар, сумд мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага, үйлчилгээний газруудаас хураан авч орон нутгийн төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлэн зохиох журмын дагуу зарцуулж, тухайн жилийн биелэлт үр дүнг оны эцсийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг Засаг дарга (Ж.Дорждэрэм)-д үүрэг болгосугай.

3.Холбогдох баримт бичгийг бүрдүүлж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд бүртгүүлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Г.Мөнхтуяа), Байгаль орчны улсын байцаагч (Б.Батболд) нарт үүрэг болгосугай.

4.Уг тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Х.ГАНТУЛГА

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
31 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт*

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН
НЭГЖ ТАРИФЫН ХЭМЖЭЭ**

дд	Хог хаягдал гаргагч эх үүсвэр	Хураамжийн хэмжээ / төгрөг/
Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж үнэ		
1	Айл, өрх албан байгууллагын энгийн хог хаягдал тээвэрлэх тариф	Үндсэн тэвш-20000
		1 шоошиг-3500
		1 уут-2000 /50кг уут/

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
31 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

1	Өрхөөр	300 (сар бүр)
2	Аж ахуйн нэгж, Худалдаа үйлчилгээний газар / дэлгүүр, гуанз,баар,ресторан, хоол үйлдвэрлэл, зочид буудал/	5000 (сар бүр)
3	Ил задгай талбайд худалдаа үйлчилгээ эрхлэгчид, баяр наадмын үеэр барьсан цайны газар бусад цэгүүд	5000 (сараар)
4	Шатахуун түгээх станц	10000 (сар бүр)
5	Албан байгууллага	5000 (сар бүр)
6	Дулаан үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж	10000 (ажиллаж буй сар)
7	Дугуй засвар	5000 (сар бүр)
8	Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж	Сард (25000 x 12) Жилд (300,000)

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 7521 дүгээрт бүртгэв.

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар
хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.4, 27¹.1.9-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Өвс, тэжээл хадгалах, тээвэрлэхэд дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”-ийг хавсралтаар тус баталсугай.

2. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд (М.Бадамсүрэн), Онцгой байдлын ерөнхий газрын дарга (хошууч генерал Г.Ариунбуян), Цагдаагийн ерөнхий газрын дарга, (хошууч генерал Ж.Болд)-д тус тус даалгасугай.

3. Энэ тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Х.ГАНХУЯГ

*Улсын онцгой комиссын даргын
2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
8 дугаар тушаалын хавсралт*

ӨВС, ТЭЖЭЭЛ ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХЭД ДАГАЖ МӨРДӨХ ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮРЭМ

Нэг. НИЙТЛЭГҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь хүний амь нас, эрүүл мэнд, өвс, тэжээл хадгалах, тээвэрлэх, хураах үеийн галын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Иргэн, хуулийн этгээд нь өвс, тэжээлийг хадгалах, тээвэрлэх, хураахдаа Галын аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм” болон энэхүү дүрэм, бусад эрх зүйн актыг заавал дагаж мөрдөнө.

1.3. Аюулгүй байдлын үзүүлэлт нь энэхүү дүрэмд заасан түвшнээс илүү, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн техник технологийг өвс, тэжээлийг хадгалах, тээвэрлэх, хураах үеийн галын аюулгүй байдалд иж бүрнээр ашиглах тохиолдолд тухайн технологийн холбогдох дүрмийг баримтлахыг зөвшөөрнө.

1.4. Дүрмийн хэрэгжилтэд Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан хяналт тавина.

1.5. Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1. “Тэжээл” гэж бүх төрлийн таримал ургамал, хивэг, будаа, багсармал тэжээл зэргийг.

Хоёр. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1. Иргэн, хуулийн этгээд нь өөрийн эдэлбэр газарт галын аюулгүй байдлыг ханган хашаа, хайсыг барьж байгуулан дүрмийн 3.7, 3.17-д заасан хамгаалалтын зурвас татсан байна.

2.2. Хуулийн этгээд нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10 дах хэсэгт заасан гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг аймаг, нийслэл, орон нутгийн гал түймэртэй тэмцэх байгууллагаар батлуулна.

2.3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор жилд 1 удаа гал түймэр унтраах, урьдчилан сэргийлэх дадлага, сургалтыг зохион байгуулсан байна.

2.4. Өвс тэжээл хадгалах газарт Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 2.2-т заасны дагуу гал түймэр гарсан үед гарах аврах зам, гарц, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн байршлыг төлөвлөлтийн зурагт байршуулж, харагдахуйц газар байрлуулна.

2.5. Орон нутагт өвс, тэжээлийг хадгалах байгууламжийн байрлалыг сонгохдоо ерөнхий сүлжээний автозамаас хамааран дараах зай хэмжээг баримтална.

- а. олон улсын чанартай авто замаас 150 м-ээс багагүй;
- б. улсын чанартай авто замаас 100 м-ээс багагүй;
- в. орон нутгийн чанартай авто замаас 50м-ээс багагүй;
- г. нийслэлийн авто замаас 50 м-ээс багагүй;
- д. аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто замаас 30м-ээс багагүй.

2.6. Өвс тэжээлийг тээвэрлэх дээ иргэн, хуулийн этгээд нь Өвс, тэжээл тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага. MNS 5647:2006 стандартыг мөрдөнө.

Гурав. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГА

3.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өвс, тэжээл хадгалж байгаа объектод хяналтын цэг байгуулж, гал гарсан үед холбоо барих, дохио өгөх хэрэгслээр хангасан байна.

3.2. Хэт нойтон өвсийг боохыг хориглоно. Өвсийг MNS 0592:2008 “Өвс. Техникийн шаардлага”-ын дагуу 15 хувиас ихгүй чийгтэй үед нь шахалтын нягт нь $120-150 \text{ кг/м}^3$ -ээс багагүй байхаар бооно.

3.3. Өвсийг хуурай сэрүүн агуулах, саравчинд хананаас 1 м, шалнаас 20 см зайтай мөн ус шорооноос хамгаалсан хучлага дор нуруулдан хурааж, 20 сар хүртэл хугацаагаар хадгалж болно.

3.4. Өвсийг тогтоосон хэмжээнээс илүү чийгтэй нуруулдахыг хориглоно. 2 сараас дээш хугацаагаар буюу байнга хадгалах газрын нэг нуруунд 1038 боодол /түүнтэй дүйцэхүйц хэмжээний хуйлсан өвс/ өвс байхаар хураана.

3.5. Боосон өвсийг нуруулдахдаа 8 үе хүртэл давхарлан өрөөд 9 дэх үеэс эхлэн шатлах журмаар 2 талаас нь 15 см-ээр дутуу тавьж 7 үе хураана. Нурууны өндөр нь 15 үе буюу 5-6 метрээс өндөргүй, талбай нь $24-40 \text{ м}^2$ байж болно.

3.6. Нурууны урт, хөндлөнгийн дагуу үе бүрт 2-оос доошгүй салхи орох нүхийг өргөн нь 10 см, өндөр нь 36 см байхаар гаргаж өвс ялзрах, өөрөө авалцан асах, халах аюулаас хамгаална. 3.7. Иргэн, аж ахуй нэгж байгууллагын өвс, тэжээлийн эргэн тойронд хашааг өвснөөс 8-10 метр зайтайгаар барина. Хашаа нь 1.5 метрээс доошгүй өндөртэй, гадагшаа онгойдог 3-аас доошгүй хаалгатай байна.

3.7. Нуруулдсан өвс хооронд 20 метр өргөн зайтай 20 нуруу өвсийг нэг хэсэг болгох ба хэсэг хооронд 100 метр зайгаар тусгаарлахаас гадна хэсгүүдийн эргэн тойронд 15 метр зайд 3 метрээс багагүй өргөнтэйгөөр газрын хөрсийг хаглаж зурвас татна.

3.8. Нуруу, хэсгүүдийн хооронд сул өвс байлгахыг хориглоно. Сул задгай өвсийг цаг тухайд цэвэрлэн өвс хадгалж буй хашаан дахь сул өвсийг тухай бүр боож, хог ургамал болон хогийг тогтмол цэвэрлэнэ.

3.9. Нуруулдсан өвсөнд авто машиныг тулгаж, зогсоох, задгай өвсөн дээгүүр унуулж зогсоох, явуулахыг хориглоно. Машин доорх өвсийг хамж, цэвэрлэж авсны дараа уг машиныг асааж хөдөлгөнө.

3.10. Өвс, тэжээл бэлтгэх тээвэрлэхэд ажиллаж байгаа бүх төрлийн машин, техник, тракторын утааны янданд нь оч баригчтай байна.

3.11. Өвс, тэжээлийг хадгалах, хураах объектыг төмөр замаас 200 метр, газрын тосны бүтээгдэхүүний агуулахаас БНБД 21-03-04 “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүйн норм”-ын 2-р хүснэгтэд заасан зай хэмжээг, шатахуун түгээх станцаас БНБД 21-07-14 “Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм”-ын 1-р хүснэгтэд заасан зай хэмжээг тус тус баримтлан байрлуулна.

3.12. Өвс, тэжээлийг хадгалах, борлуулах цэгийг цахилгааны шугамаас 15 метр, барилга байгууламжаас 50 метрээс багагүй зайд байрлуулна.

3.13. Өвс тэжээлийг тээврийн хэрэгсэлд ачиж зогссон бол /чиргүүл мөн хамаарна/ тээврийн хэрэгсэл хоорондын зай 10-аас доошгүй метрийн зайтайгаар байрлуулна.

3.14. Айл, өрх өвс, тэжээлийг хадгалахдаа 3.11 дэх заалтыг баримтална. Өөрийн амьдардаг хувийн орон сууцныхаа янданд оч баригч байрлуулсан тохиолдолд 3.13-д заасан зай хэмжээг 30 хүртэл хувиар багасгаж болно.

3.15. Иргэн, хуулийн этгээд нь харуулын өндөрлөг, манааны байрыг салхины доод талд өвс хадгалах хашааны гадна талд байрлуулна.

3.16. Өвс, тэжээлийг хадгалсан газруудад 100 метрээс дотогш зайд тамхи татах, ил гал гаргахыг хориглоно.

3.17. Өвсний агуулахын хашаанаас ойр орчмын ойн бүс хүртэл 20 метрээс багагүй зайд 4 метрээс багагүй өргөнтэйгөөр газрын хөрсийг хаглаж зогоон татна.

3.18. Өвс, тэжээл хадгалж буй объектод (хашаа, саравч г.м) орохдоо тамхи чүдэнз, асаагуурын хэрэгслээ жижүүр буюу манаачийн байранд орхино.

3.29. Өвс, тэжээл хадгалж буй объектод тавигдсан цахилгааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжүүд нь цахилгаан техникийн аюулгүйн дүрмийн шаардлагыг бүрэн хангасан байна.

3.20. Өвс тэжээл хадгалж буй барилга байгууламжид БД 43-103-08 “Аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар”-ын аянга зайлуулагчийг төлөвлөсөн байх шаардлагатай ба аянга хүлээн авагч, дамжуулагч, газардуулга нь ямар нэгэн механик гэмтэлд өртөөгүй

байна.

3.21. Өвс, тэжээл хадгалж буй объектод дараах зүйлсийг хориглоно.

3.21.1.Хялбар авалцан асах, тэсэрч дэлбэрэх, шатамхай шингэн болон хуурай бодис, шахсан болон шингэрүүлсэн хийн сав, тэсрэх бодис, төрөл бүрийн шатах материал хураах, хадгалахыг;

3.21.2.Лаа, чүдэнз, дэн, дэнлүү, түүдэг гал, бамбараар гэрэлтүүлэх;

3.21.3.Цахилгааншугамсүлжээгилмонтажлах,зөвшөөрөгдөөгүй болон гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл ашиглах;

3.21.4.Ажиллаж буй техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эзэнгүй орхих, хүчдэлээс салгаагүй үед засвар үйлчилгээ хийх;

3.21.5.Гал унтраах үйл ажиллагаанаас бусад зүйлд анхан шатны багаж хэрэгслийг ашиглах;

3.21.6.Галын аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй ажилтан, алба хаагч тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ажиллуулах;

3.22. Цахилгаан улайсах гэрэлтүүлэг ашигласан тохиолдолд тэсрэлтээс хамгаалсан бүрхүүлээр хамгаална. Үүнийг нуруулдсан өвс, сүрлээс 5 метрээс доошгүй зайтайгаар шонд 4-6 метрийн өндөрт байрлуулна.

3.23. Өвс, тэжээлийг хадгалах газрын дэргэд буюу хашаан дотор трактор, авто машин өөрөө явагч механизмд засвар хийх, шатахуун сэлбэх, моторыг асаалттай эзэнгүй орхихыг хориглоно.

Дөрөв. ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АНХАН ШАТНЫ БАГАЖ ХЭРЭГСЭЛ

4.1. Өвс, тэжээлийг бэлтгэх, тээвэрлэх, хураах ажилд хэрэглэгдэж байгаа бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсөгт 1-ээс доошгүй гал унтраагуур, төмөр хүрз, цохиур бэлтгэн тавина.

4.2. Өвс, тэжээл хадгалах барилга байгууламжид хувин, дэгээ, сэрээ, цохиур, бургасан шүүр, бүтээлэг зэргийг хүрэлцэх хэмжээгээр бэлтгэн тавина.

4.3. Гал түймэр гарсан үед шатаж байгаа нуруутай өвс, тэжээлийг таслах, нураах, зөөх, тусгаарлах ажилд зориулан тусгай төлөвлөгөө бүхий бэлтгэлтэй байна.

4.4. Айл, өрх үнс нурмаа ухаж бэлтгэсэн хаалт, таглаа бүхий нүхийг салхины чиглэлийн доод талд байрлуулж, өрх бүр гал гарсан үед ашиглах багаж хэрэгсэлтэй байна. (гал унтраагуур, хүрз, хувин, дэгээ, эсгий, цохиур г.м)

4.5. Нуруулдсан өвс, тэжээлээс 50 метрийн зайнд хог хаягдал шатаахыг хориглоно. Хүн ам төвлөрсөн суурин газар болон ойн захаас 100 метрийн зайд шатамхай эд зүйлийг хараа хяналтгүй орхих, ил галын тусламжтай халж хөөрдөг (гэрэлт зул) хэрэгсэл ашиглахыг хориглоно.

4.6. Өвс, тэжээл хадгалах барилга байгууламжийг MNS 5566-2020-т заасны дагуу 10м³ хүртэл багтаамж бүхий усан сан, ус сорох, шахах мотопомп, галын хоолой, хошуугаар тоноглоно.

Тав. ӨВС, ТЭЖЭЭЛ ТЭЭВЭРЛЭХ ҮЕД ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

5.1. Өвс, тэжээл ачсан автомашин, трактор дээр хүн суулгах, өөр төрлийн ачаа ачих, тээвэрлэлтийн үед кабиндаа тамхи татахыг хориглоно.

5.2. Өвс, тэжээлийг тээвэрлэхдээ 5 кг-аас багагүй багтаамж бүхий гал унтраагуурыг тэвшний хашлаганы гадна талд хялбар авч болохоор бэхэлсэн байна.

5.3. Өвс, тэжээл ачих, буулгах үед тээврийн хэрэгслийг бүрэн унтрааж мотор, утааны яндан, гишгүүр болон бүх агрегатууд дээр унасан сул өвс, сүрэл, зэгс ногоон тэжээлийг бүрэн цэвэрлэж байж хөдөлнө.

5.4. Өвс, тэжээлийг тэвш, чиргүүлд бүтээлэгтэй тээвэрлэхдээ энэ дүрмийн 5.1, 5.2, 5.3-р заалтыг нэгэн адил биелүүлнэ.

5.5. Өвс, тэжээлийг төмөр замаар тээвэрлэх үед зөвхөн битүү вагонд ачна.

5.6. Өвс, тэжээлийг эзгүй хээр хамгаалалтгүй орхихыг хатуу хориглоно.

Зургаа. БУСАД ЗҮЙЛ

6.1. Байгууллагын удирдлага, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд галын аюулгүй байдлыг хангуулах эрх бүхий албан тушаалтан нь галын аюулгүй байдлын хууль тогтоомж, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүрмийг зөрчсөн тохиолдолд үйл ажиллагааг нь хэсэгчлэн болон болон бүр мөсөн зогсоох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

6.2. Энэхүү дүрмийг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 7522 дугаарт бүртгэв.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 26

Дархан сум

НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан «Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал»-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (Н.Буманцэцэг)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.ЯНЖМАА

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
26 дугаар тогтоолын хавсралт*

**НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ
ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тариф/төгрөг
1	Нэг м2 талбайг цэвэрлэхэд шаардагдах зардал	м2	25

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тариф/төгрөг
1	Нэг тонн хог хаягдлыг дарж булах зардал	тн/төг	14350

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7523 дугаарт бүртгэв.

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЛИГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 8/16

Хатан суудал

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Малын тоо, толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Сумын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээдийн нэг толгой малд ноогдуулах малын тоо, толгойн албан татварын хувь хэмжээг Адуу-100 төгрөг, Үхэр-100 төгрөг, Тэмээ-100 төгрөг, Хонь-100 төгрөг, Ямаа-100 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Малын тоо толгойн албан татварыг сумын төсөвт төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулж, сумын нийт иргэдэд мэдээлэх, танилцуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга (С.Энхзул)-д даалгасугай.

3.Малын тоо, толгойн албан татвар тогтоох тухай хуулийн дагуу батлагдсан албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журмыг мөрдөн ажиллахыг Татварын улсын байцаагч (Ш.Жаргалмаа)-д даалгасугай.

4.Хуульзүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоолыг холбогдох бичиг баримтын хамт хүргүүлэх, мөн тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Б.Эрдмаа)-д хариуцуулсугай.

5.Энэхүү тогтоол гаргасантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит 12 дугаар сарын 15-ны өдрийн 10/05 дугаар тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА


С.БАТТУЛГА

980107239

1. අනුමැතිය ලබාදීම සඳහා
 අනුමැතිය ලබා දීමේදී
 2. අනුමැතිය ලබාදීම සඳහා

५७६

श्रीगुरुभ्यो नमः



880

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7524 дүгээрт бүртгэв.

БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар IX/09

Булган сум

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн IX хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг нэгдүгээр, энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифын хэмжээг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ, хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг тогтоосон хэмжээний дагуу мөрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д даалгасугай.

3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн IX/11 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Уг тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Л.ГАНЗОРИГ

**Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ес дэх удаагийн сонгуулийн ээлжит IX хуралдааны
IX/09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт**

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

д/д	Хураамж төлөгч		Хэмжих нэгж	Хураамж /төгрөгөөр/	Тайлбар
1	Айл өрх (иргэн)		Сард	5100	Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 7 сарын 19-ний өдрийн 192, А/243 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар тооцсон.
2	Худалдааны төв		Сард	80000	
3	Зах		Сард	80000	
4	Гуанз, цайны газар, нийтийн караоке, ресторан	50 хүртэл суудалтай	Сард	50000	
		100 хүртэл суудалтай		80000	
5	Хүнсний дэлгүүр		Сард	40000	
6	Төрийн байгууллага (ажилчдын тоо)	20 хүртэл	Сард	30000	
		21-50 хүртэл		50000	
		50-аас дээш		80000	
7	Сургууль		Сард	120000	
8	Цэцэрлэг		Сард	60000	
9	ОНӨҮГ, Компани, Үйлдвэр		Сард	40000	
10	Нэгдсэн эмнэлэг		Сард	200000	
11	Хувийн эмнэлэг		Сард	40000	
12	Шатахуун түгээх станц		Сард	50000	
13	Талх, нарийн боов, зайрмаг, хиам, хэрчсэн гурил, цэвэр усны цех,		Сард	40000	
14	Үсчин гоо сайхан		Сард	30000	
15	Зурагчин, өнгөт хэвлэлийн газар		Сард	30000	
16	Зочид буудал		Сард	50000	
17	Автомашин угаалгын газар, дугуй засвар		Сард	30000	

Тайлбар: Сумын төвийн айл өрхүүдээс цаасан болон цахим хэлбэрээр санал асуулга авч өрхийн ам бүлийн тоог санал асуулга дээр тусган дунджаар 3 ам бүлээр тооцон 1 иргэнд 1700 төгрөг байхаар тооцоолов.

*Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ес дэх удаагийн сонгуулийн ээлжит IX хуралдааны
IX/09 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫГ
НЭГЖ ТАРИФ**

Үзүүлэлтүүд	Нэгж	Тариф / төг/
Нэг тн хогийг тээвэрлэх зардал	тн	36005

БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 49

Залаа

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь заалт, Сангийн сайд Байгаль орчны сайдын хамтарсан 2018 оны 192/243 дугаар тушаалыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, үсчин, гоо сайхан, дугуй засвар, цех, дэлгүүрүүд, албан байгууллагууд, айл өрхүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Төсөвт байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, үйлчилгээний газрууд, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд, түүний туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын хураамжийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсүгэй.

3.Өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хэмжээгээр сар бүр Эрчим хүчний үйлчилгээний төлбөртэй хамтатган төвлөрүүлж, хог хаягдлын хураамжийн орлогыг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсүгэй.

4.Орон нутгийн төвлөрүүлсэн орлогыг хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, булшлах, устгах зардалд зарцуулан ажлын үр дүн, гүйцэтгэлийг хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Л.Батхуяг)-т үүрэг болгосугай.

5.Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Цэнгэлмаа)-д даалгасугай.

6.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай” сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 102 дугаарын тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.САЙХАНБАЯР

*иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдааны
2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
49 дүгээр тогтоолын хавсралт*

**Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж
байгууллага, албан байгууллага, айл өрхүүдийн хог хаягдлын
үйлчилгээний хураамжийн хэмжээ**

№	Хог хаягдлын хураамж төлөх аж ахуйн нэгж байгууллага, албан байгууллага, айл өрхүүд	Сар бүр төлөх хураамжийн хэмжээ, төгрөг
1	Засаг даргын Тамгын газар	20000
2	Ерөнхий боловсролын сургууль	20000
3	Цэцэрлэг	20000
4	Соёлын төв	20000
5	Эрүүл мэндийн төв	20000
6	Цаг уур өртөө	20000
7	Хаан банк, төрийн банк	20000
8	Холбоо	20000
9	ШТС-ууд	20000
10	Уурын зуух	100000
11	Сумын төвийн өрхүүд	10000
12	Дэлгүүр	15000
13	Дугуй засвар, үсчин, цех	15000
14	Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, хоршоо, ТББ	15000
15	Гаднаас ирж түр хугацаагаар ил задгай наймаа эрхлэгч, ноос ноолуурын ченж, ААНБ	10000
16	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагууд	200000
17	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллага, түүний туслан гүйцэтгэгч	500000
18	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагын (кемпийн, замын, барилгын, өрөмдлөг, хайгуул болон бусад үйл ажиллагаа эрхлэгч) туслан гүйцэтгэгчид	500000

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7526 дугаарт бүртгэв.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 52

Залаа

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.14 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь заалт, 6.2 дахь заалт, 6.3 дахь заалт, 6.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг малын төрөл тус бүрээр “0” (тэг) төгрөгөөр тогтоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж иргэд малчдад мэдээлж сурталчлан ажиллахыг сумын Засаг дарга (Л.Батхуяг)-т үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Цэнгэлмаа)-д даалгасугай.

4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 18 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Н.САЙХАНБАЯР

БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 10/66

Номгон

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29.1.12, 29.1.14, 35.1.4-35.1.13, 35.1.15-35.1.18, 35.1.21, 35.1.22 дахь заалт, 35.4-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг шинэчлэн хавсралтаар баталсугай.


2.Шийдвэрийг холбогдох байгууллага, ард иргэдэд сурталчлан таниулж, батлагдсан хувь хэмжээгээр хураамжийг төвлөрүүлэн ажиллахыг аймгийн Засаг дарга (Э.Энхбат), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хууль эрх зүй, төлөөлөгчийн ёс зүйн хороо (Б.Соронзонбаатар)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 5/18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.БАТСУУРЬ



১৯৪৭ খ্রিঃ ১০ মার্চ ১৯৪৭ খ্রিঃ
 ১৯৪৭ খ্রিঃ ১০ মার্চ ১৯৪৭ খ্রিঃ



889

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
10/66 дугаар тогтоолын хавсралт*

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн заалт	Тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээ /мян.төг/
1	2	3
1	29.1.12.Улсын тусгай хамгаалалттай газар нутгаас бусад газарт байрлах отоглох цэгээр үйлчлүүлэхэд нэг хүн /3.0-10.0/	3.0
2	29.1.12.Улсын тусгай хамгаалалттай газар нутгаас бусад газарт байрлах отоглох цэгээр үйлчлүүлэхэд нэг автомашин /5.0-10.0/	10.0
3	29.1.14.Орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход /3,000.0-10,000.0/	3,000.0
4	35.1.4.Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход /200.0-1000.0/	500.0
5	35.1.5.Тамхи худалдах зөвшөөрөл олгоход /100.0-500.0/	100.0
6	35.1.6.Ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх тусгай зөвшөөрөл олгоход /96.0-480.0/	150.0
7	35.1.7.Ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд /32.0-160.0/	50.0
8	35.1.7.100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрээг сунгахад /20.0-100.0/	30.0
9	35.1.8.Усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад /40.0-200.0/	80.0
10	35.1.9.Ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход /48.0-240.0/	80.0
11	35.1.10.Нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход /40.0-200.0/	60.0
12	35.1.11.Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход /8.0-40.0/	12.0

13	35.1.12.Ан амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоход /1.0-10.0/ .	2.5
1	2	3
14	35.1.13.Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад /400.0-2,000.0/	800.0
15	35.1.15.Ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд /1.2-6.0/	2.5
16	35.1.16.Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл олгоход /1.0-4.0/	1.5
17	35.1.17.Элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд /4.0-20.0/	6.0
18	35.1.18.Ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 0-10 килограмм бол /1.0-4.0/	2.0
19	35.1.18.Ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд /0.05-0.2/	0.1
20	35.1.21.Малын удам гарвалын болон эрүүл мэндийн гэрчилгээ, шилжилт хөдөлгөөний тодорхойлолт, мал, үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ олгоход /2.0-10.0/	2.5
21	35.1.21.Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх итгэмжлэлийн гэрчилгээ олгоход /2.0-10.0/	10.0
22	35.1.22.Рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход /125.0-640.0/	280.0
23	35.4.Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход /40.0-100.0/	50.0
35.5.1.Мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгоход		
24	6м3 хүртэл /1.0-3.0/	3.0
25	6-10м3 хүртэл /1.5-4.5/	4.5
26	10-20м3 хүртэл /2.0-6.0/	6.0
27	20-60м3 хүртэл /5.0-15.0/	15.0
35.5.2.Ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход		
28	8м³ хүртэл /1.5-4.5/	4.5
29	8-10м³ хүртэл /2.0-6.0/	6.0
30	10-20м³ хүртэл /3.5-10.5/	10.5
31	20-30м³ хүртэл /5.0-15.0/	15.0
35.5.3.Ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход:		
32	0-10м³ /1.0-3.0/	3.0
33	10-20м³ /1.2-3.6/	3.6

34	20-30м³/1.5-4.5/	4.5
35	35.5.4.Арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол /1.0-2.0/	2.0
36	35.5.4.Арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход 10 куб метрээс дээш бол 1000-2000 төгрөг дээр 10-аас дээш сийрэг куб метр тутамд нэмж /0.1-0.15/	0.15
37	35.5.5.Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнз, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол /1.0-2.0/	2.0
38	35.5.5.Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнз, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход 10 куб метрээс дээш бол 1000-2000 төгрөг дээр 10-аас дээш куб метр тутамд нэмж /0.1-0.15/	0.15

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7528 дугаарт бүртгэв.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ БАЯННУУР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 28

Цул-Улаан

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 тушаалын 1 дүгээр хавсралтад заасныг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зургаадугаар хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоож, хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан тарифын дагуу аж ахуйн нэгж, албан байгууллага, айл өрхүүдэд дагаж мөрдүүлж, тогтоолын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга /Н.Мендигүл/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын дэргэдэх эдийн засгийн байнгын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ЕСКЕНДИР

**Сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 12-ны
өдрийн ээлжит зургаадугаар хуралдааны
28 дугаар тогтоолын хавсралт**

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ

№	Айл өрх, ААН, Байгууллага		Хураамж /сард.төг/
1	Төвлөрсөн халаалттай болон галлагаатай орон сууц, гэр хорооллын айл өрх		4000
2	Нийтийн болон дотуур байр		10000
3	Зочид буудал, амралтын газар	15 хүртэл ортой	15000
		15-30 ортой	25000
		30-с дээш ортой	35000
4	Хүүхдийн цэцэрлэг, ясли		10000
5	ЕБСургууль		10000
6	Номын сан, музей		5000
7	Сүм, хийд болон нийтийн амралт зугаалгын бүс		2000
8	Худалдаа төв, зах, төрөлжсөн дэлгүүр, бөөний төв	40м² –аас бага талбайтай	5000
		40м² -100м² талбайтай	6000
		100м²-200м² талбайтай	10000
9	Ресторан, гуанз бар, кафе	20 хүртэл суудалтай	10000
		20-50 хүртэл суудалтай	15000
		50-аас дээш суудалтай	20000
10	Талх, нарийн боов, хэрчсэн гурил, хиа, зайрмаг, цэвэр усны цех болон бусад жижиг үйлдвэрлэл		6000
11	Үсчин, ахуйн үйлчилгээ, гутал засвар, оёдлын цех, гар утас засвар, тоглоомын газар, зурагчин компьютер үйлчилгээ		5000
12	Албан байгууллага, ажлын өрөө	10 хүртэл ажилтантай	5000
		10-с дээш ажилтантай	10000
13	Сумын төвд мал аж ахуй болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч		30000
14	Түц		5000
15	Шатахуун түгээх станц		10000
16	Дугуй засвар, авто угаалга, засвар		8000
17	Халуун усны газар		10000
18	Модны цех, хөрөө рам, эсгийний үйлдвэр		10000
19	Мал амьтны түүхийн эд авах цэг		30000
20	Мал нядалгааны цэг		100000
21	Нийтийн эзэмшлийн газар гадаа талбайд худалдаа үйлчилгээ эрхэлдэг /улирлын чанартай/		5000
22	Цахилгаан дамжуулах , түгээх салбар, дулааны үйл ажиллагаа явуулдаг ААН		30000
23	Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулдаг ААН, нөхөрлөл		30000

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7529 ддүгээрт бүртгэв.

ХОВД АЙМАГ БУЯНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 7/05

Зургаа

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчины сайдын хамтарсан 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 192, А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын Засаг даргын саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VII хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Хог хаягдлын хураамжийн төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг олон нийтэд таниулан сурталчилах арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга /Ж.Бумбат/-д даалгасугай.

3.Хог хаягдлын хураамжийг хуулийн хүрээнд төвлөрүүлэн, сум орон нутгийн орлогыг нэмэгдүүлж ажиллахыг татварын улсын байцаагч /Ү.Баярмаа/, Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, нийтэлсэний дараа дагаж мөрдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Р.ДЭМБЭРЭЛ

*Буянт сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар
сарын 16-ны өдрийн ээлжит VII хуралдааны
7/05 тоот тогтоолын хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Хураамж төлөгч	Хураамж	Төлөх хугацаа
1	Засаг даргын Тамгын газар	10000	Сар бүр
2	Ерөнхий боловсролын сургууль	15000	Сар бүр
3	Хүүхдийн цэцэрлэг	10000	Сар бүр
4	Эрүүл мэндийн төв	15000	Сар бүр
5	Соёлын төв	5000	Сар бүр
6	Аж ахуйн нэгж, хүнсний дэлгүүр	10000	Сар бүр
7	Эмийн сан	5000	Сар бүр
8	Банк санхүүгийн байгууллага	10000	Сар бүр
9	Үсчиний газар	5000	Сар бүр
10	Шатахуун түгээх станц	10000	Сар бүр
11	Авто засвар, дугуй засвар	5000	Сар бүр
12	Сумын төвийн айл өрх	1200	Сар бүр
13	Хөдөөгийн багийн айл өрх	1200	Сар бүр
14	Уурын зуух	15000	Сар бүр
15	Халуун усны газар	10000	Сар бүр
16	Суманд үйл ажиллагаа явуулдаг хайгуулын болон ашиглалтын лизензтэй аж ахуй нэгж, байгууллага	42000	Сар бүр

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7530 дугаарт бүртгэв.

ХОВД АЙМАГ БУЯНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 7/06

Зургаа

БУЯНТ СУМЫН МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАР ТОГТООХ ТУХАЙ

Монгол Елсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Засаг даргын саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VII хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1. Малын тоо толгойн албан татварыг дараах төрлөөр тогтоосугай.

Адуу- 1000 төгрөг

Үхэр- 1000 төгрөг

Тэмээ- 0 төгрөг

Хонь- 250 төгрөг

Ямаа- 250 төгрөг

2. Тогтоол гарсантай холбогдуулан малын тоо толгойд ногдуулсан татварыг хураах ажлыг зохион байгуулж, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын талаар сургалт, сурталчилгаа хийж ажиллахыг сумын Засаг дарга, Татварын улсын байцаагч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 15/06 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Р.ДЭМБЭРЭЛ

АРХАНГАЙ АЙМАГ ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 08/06

Хөшөөт

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит наймдугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг Тэмээ 800 төгрөг, адуу 800 төгрөг, үхэр 800 төгрөг, хонь 300 төгрөг, ямаар 300 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол бусад холбогдох материалуудыг бүрдүүлэн, эрх бүхий дээд байгууллагад хүргүүлж бүртгүүлэхийг сумын Засаг дарга /Д.Энхжаргал/-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03/08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Х.БҮРЭНБААТАР

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7532 дугаарт бүртгэв.

АРХАНГАЙ АЙМАГ ЦАХИР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 07/23

Хан-Уул

ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь :

1.2026 онд малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээдээс сумын төсөвт төвлөрүүлэх мал тоо толгойн албан татварын шинэчилсэн хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2.Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

3.Уг тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дүгээр сарын 19-ны өдрийн 03/09 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

В.БАЯНТӨР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
07/23 дугаар тогтоолын хавсралт

**МАЛЫН ТОО ТОЛГОЙН ЖИЛД НОГДУУЛАХ АЛБАН ТАТВАРЫН
ХЭМЖЭЭ**

№	Малын төрөл	Хэмжээ /төгрөгөөр/
1	Хонь	500
2	Ямаа	500
3	Үхэр	800
4	Адуу	1000
5	Тэмээ	0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7533 дүгээрт бүртгэв.

УВС АЙМАГ ӨЛГИЙ СУМ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 6/05

Хар ус

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6,2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сумын мал бүхий өрхөөс авах малын тоо толгойн татварыг дор дурдсанаар шинэчлэн тогтоосугай.

- тэмээний тоо толгой тутамд 300 төгрөг, адууны тоо толгой тутамд 300 төгрөг, үхрийн тоо толгой тутамд 300 төгрөг, хонины тоо толгой тутамд 300 төгрөг, ямааны тоо толгой тутамд 300 төгрөг байхаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Тогтоосон татварыг хагас бүтэн жилээр төвлөрүүлж ажиллахыг Сумын татварын байцаагч (М.Дарьсүрэн)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 28 ны өдрийн 3/03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (М.Даваасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ОЧИРБАТ

УВС АЙМАГ ДАВСТ СУМ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 7/06

Зүүнхөвөө

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал бүхий этгээдийн малын тоо толгой тутамд ногдуулах албан татварын хэмжээг дор дурдсанаар шинэчлэн тогтоосугай. Үүнд:

Адуу - 300

Тэмээ - 300

Үхэр - 300

Хонь - 300

Ямаа - 400 төгрөг

2. Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон энэ тогтоолыг хэрэгжүүлж, малын тоо толгойн албан татварын орлогыг сумын төсөвт тусган батлуулж, Төсвийн тухай хууль, зохих журмын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга (Г.Лхагважав)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга (П.Түмэндэлгэр)-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/04 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

П.ТҮМЭНДЭЛГЭР

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7535 дугаарт бүртгэв.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 130

Улаанбаатар
хот

АРХАНГАЙ АЙМГИЙН “АРХАНГАЙН УС СУВАГ” ОНӨААТҮГ-ЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА БОЛОН ЗӨӨВРИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ, СУУРЬ ХУРААМЖ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Архангай аймгийн “Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын төсөвт байгууллагад мөрдөгдөх цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, зөөврийн ус хангамж, бохир ус зөөврөөр татан зайлуулах үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг “Архангайн ус суваг” ОНӨААТҮГ /Б.Энхсайхан/-т үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Архангайн ус суваг” ОНӨААТҮГ /Б.Энхсайхан/-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 81 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт, 2023 оны 27 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын хоёрт заасан цэвэр, бохир усны “төсөвт байгууллагууд”, “зөөврөөр” гэсэн тариф болон хоёрдугаар хавсралтыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг
Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын
ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
130 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**Нэг. “Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын
төсөвт байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф
(НӨАТ-гүй)**

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	төг/л	5.07
2.	Бохир ус	төг/л	5.07

**Хоёр. “Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын зөөврийн ус хангамж,
бохир ус зөөврөөр татан зайлуулах үйлчилгээний тариф
(НӨАТ-гүй)**

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	төг/л	9.23
2.	Бохир ус	төг/л	22.10

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын
ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
130 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**АРХАНГАЙ АЙМГИЙН “АРХАНГАЙН УС СУВАГ” ОНӨААТҮГ-ЫН
ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
11.	150	156,600	37,800
15.	400=<	576,000	115,200

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7536 дугаарт бүртгэв.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 128

Улаанбаатар
хот

УВС АЙМГИЙН УЛААНГОМ СУМЫН “ЧАНДМАНЬ УВС” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Увс аймгийн Улаангом сумын “Чандмань Увс” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг “Чандмань Увс” ХХК /Б.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Чандмань Увс” ХХК /Б.Алтангэрэл/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 89 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтыг, 2019 оны 102 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг, Зохицуулах хорооны 2024 оны 91 дүгээр тогтоолыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА
ГИШҮҮН

Г.ЦОГТСАЙХАН
Б.АЛТАНТУУЛ
Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 28 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

УВС АЙМГИЙН УЛААНГОМ СУМЫН “ЧАНДМАНЬ УВС” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	1.5
	Тоолуургүй	төг/л	3.0
	Ус түгээх байр	төг/л	1.82
Бохир ус	Тоолууртай	төг/л	1.5
	Тоолуургүй	төг/л	3.0

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	7.0
	Төсөвт байгууллага	төг/л	10.5
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	10.5
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	10.5
	Дулааны станц	төг/л	3.5
Бохир ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	10.5
	Төсөвт байгууллага	төг/л	10.5
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	10.5
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	10.5
	Зөөврөөр	төг/л	30.0

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын
ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
128 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**УВС АЙМГИЙН УЛААНГОМ СУМЫН “СУАТ” ХХК-ИЙН ЦЭВЭР,
БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
11.	150	156,600	37,800
15.	400=<	576,000	115,200

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 132

Улаанбаатар
хот

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН “СУАТ” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баян-Өлгий аймгийн “СУАТ” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг “СУАТ” ХХК /С.Нурбек/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “СУАТ” ХХК /С.Нурбек/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 85 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, 2021 оны 67 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, Зохицуулах хорооны 2023 оны 87 дугаар тогтоолыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ
Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын
ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны
2025 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн
132 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН “СУАТ” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	1.86
	Тоолуургүй	төг/л	2.08
Бохир ус	Тоолууртай	төг/л	1.86
	Тоолуургүй	төг/л	2.08

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	6.5
	Төсөвт байгууллага	төг/л	8.8
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	6.8
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, эмнэлэг	төг/л	7.2
Бохир ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	6.9
	Төсөвт байгууллага	төг/л	9.6
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	7.2
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, эмнэлэг	төг/л	7.9
	Зөөврөөр	төг/л	35.0

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын
ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
132 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН “СУАТ” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
11.	150	156,600	37,800
15.	400=<	576,000	115,200

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7538 дугаарт бүртгэв.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 134

Улаанбаатар
хот

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “УСДУ” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говьсүмбэр аймгийн “УСДУ” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн хугацааны дараа сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг “УСДУ” ОНӨААТҮГ /Б.Ганзориг/-т үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “УСДУ” ОНӨААТҮГ /Б.Ганзориг/-т даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 30 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2021 оны 50 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Зохицуулах хорооны 2024 оны 105 дугаар тогтоолын хавсралтыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг
Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын
ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
134 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “УСДУ” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР
УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Айл өрх /тоолууртай/	төг/л	2.20
	Ус түгээх байр	төг/л	3.00
Бохир ус	Айл өрх /тоолууртай/	төг/л	2.20

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	ААНБайгууллага	төг/л	10.10
	Төсөвт байгууллага	төг/л	11.60
	Зөөврөөр	төг/л	15.00
Бохир ус	ААНБайгууллага	төг/л	9.30
	Төсөвт байгууллага	төг/л	10.10
	Зөөврөөр	төг/л	40.00

*.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын
ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
134 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “УСДУ” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР
УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
11.	150	156,600	37,800
15.	400=<	576,000	115,200

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7539 дүгээрт бүртгэв.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 1 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 01/26

Дархан-Уул аймаг

ҮНЭ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйлийн 26.2, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Эрчим хүчний зохицуулах хорооны 504 дугаар тогтоол, Хонгор сумын Салхит 3-р багийн УБТЗ-ын Барилга ашиглалт үйлчилгээний нэгдүгээр ангийн хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлийн хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Дархан-Уул аймгийн Хонгор сумын Салхит 3-р багийн УБТЗ-ын Барилга ашиглалт үйлчилгээний нэгдүгээр ангийн эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг УБТЗ-ын Барилга ашиглалт үйлчилгээний нэгдүгээр ангийн дарга /Н.Ганбат /-д үүрэг болгосугай.

3. Дархан-Уул аймгийн Зохицуулах зөвлөлийн 2020 оны 05-р сарын 05-ны өдрийн 04/2020 тоот тогтоолыг тариф мөрдсөн өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /Ч.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ч.БАТЖАРГАЛ

ГИШҮҮН
ГИШҮҮН

Б.ОЮУНТУЯА
Л.БААСАНХАНД

*Дархан-Уул аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2026 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн
01/26 дугаар тогтоолын хавсралт*

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН САЛХИТ ГУРАВДУГААР
БАГ УБТЗ-ЫН БАРИЛГА АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
НЭГДҮГЭЭР АНГИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД
ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

Дархан-Уул аймгийн аймгийн Хонгор сумын Салхит 3-р багийн УБТЗ-ын Барилга ашиглалт үйлчилгээний нэгдүгээр ангийн эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний төлбөр тооцох тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамаарч дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)			
1	Усан халаалтын зуухны халаалт	Төсөвт байгууллагын халаалт		Төг/м³	1600		
2		Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт		Төг/ГЖ	-		
				Төг/м³	1600		
3		Орон сууцны халаалт		Төг/ГЖ	-		
				Төг/м²	460		
4	Аж ахуйн нэгж, байгууллага		Төг/м³	8500			
5			Хэрэгцээний халуун ус	Орон сууц	Халаалтай сард (Тоолууртай)	Төг/м³	1000
6					Халаалтгүй сард (Тоолууртай)	Төг/м³	1400

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 7540 дүгээрт бүртгэв.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 10/69

Номгон

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.4 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны “Аргачлал батлах тухай” 192, А/243 дугаар тушаалын 3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг нэгдүгээр хавсралтаар, нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх зардлын нэгж тариф болон энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Э.Энхбат), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн хороо (С.Батцэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.БАТСУУРЬ



1. Երբ որ Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք
 Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք
 2. Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք
 3. Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք
 4. Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք
 5. Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք
 6. Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք
 7. Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք
 8. Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք
 9. Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք
 10. Երևանի օրոք (2. Երևանի օրոք) և Երևանի օրոք, Երևանի օրոք, Երևանի օրոք

ԿԻՄ ԵՐԳՈՒՆ ԶՄԱՐ
 ԿՅՈՒՆ ԿԵՐԱՆՈՒՆ , ԿՈՒՍՏԱՆՈՒՆ , ԶԻՆԿԻՆՈՒՆ
 ԿԱՆԻՍՏԱՆՈՒՆ , ՕՐԿԵՍՏՐԱՆՈՒՆ , ՕՐԿ՝ ԶԵՆԻՏԱՐԱՆՈՒՆ ,
 ԿԵՂ Օ՝ ՈՐՈՒ ՈՐՄԱՆԴ Ե՝ ԿԹԻՆՈՒՆ , ԿՈՒՐՏԱՆՈՒՆ ,

$\frac{100}{50} = 2$



၁။ အထွေထွေ အချက်အလက်
 ၂။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်
 ၃။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်
 ၄။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်
 ၅။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်
 ၆။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်
 ၇။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်
 ၈။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်
 ၉။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်
 ၁၀။ အကျဉ်းချုပ် အချက်အလက်

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
10/69 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ,
ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ,
УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох зорилгоор хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, удирдлага болгон мөрдүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг сумдын Засаг даргын Тамгын газар хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дарж булшлах, устгах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага шууд хариуцан зохион байгуулна.

1.3.Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, түр болон байнга оршин суух иргэн, харьяалалгүй хүн дагаж мөрдөнө.

1.4.Журмаар зохицуулагдаагүй харилцааг Хог хаягдлын тухай хуулийг удирдлага болгон зохицуулна. Хуульд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд журамд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулна.

1.5.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх эрх бүхий этгээд гэж Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь хэсэгт заасныг ойлгоно.

1.6.Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий этгээд гэж Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.8 дахь хэсэгт заасныг ойлгоно.

Хоёр.Баримтлах зарчим болон ерөнхий шаардлага

2.1.Хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий этгээд үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

2.1.1.Хог хаягдал аль болох үүсгэхгүй байх;

2.1.2.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх, эрэлхийлэх;

2.1.3.Шинэ санаа, санаачилга гаргах, нэвтрүүлэх, шинэ арга, техник, технологи нэвтрүүлэх;

2.1.4.Хог хаягдал ангилан ялгах ажлыг ногоон буюу байгаль орчинд ээлтэй сэтгэлгээгээр хийж, хэрэгжүүлэх;

2.2.Ерөнхий шаардлага

2.2.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах үйл ажиллагааг зохих шатны Засаг даргатай гэрээ байгуулж бүртгүүлсэн эрх бүхий иргэн, аж ахуй нэгж байгууллага гүйцэтгэнэ.

2.2.2.Сумын Засаг даргатай гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, журам энэ чиглэлээр батлагдан гарсан Монгол Улсын стандартыг мөрдөн ажиллана.

2.2.3.Энгийн хог хаягдал дахин ашиглах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7-р зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэнэ.

2.2.4.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй, зааварчилга авсан байна.

2.2.5.Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, дүрэмт хувцас, ялгах тэмдэгтэй байна.

2.2.6.Харилцааны соёлд суралцсан, байгаль хамгаалах, хог хаягдлын талаар нийгмийн хариуцлагаа ухамсарласан, ажиллах хүчин байна.

2.2.7.Стандартын шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгсэл ашиглана.

2.2.8.Хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн энгийн хог хаягдал ангилах, цуглуулах тээвэрлэх, дахин боловсруулах сэргээн ашиглах, устгах, булшлах ба аюултай хог хаягдал энэ тавигдах шаардлагад хамаарахгүй.

2.2.9.Эрх бүхий этгээд нь үйл ажиллагааны тайлан мэдээг тоо хэмжээ, нэр төрөл тус бүрээр гаргаж сар бүрийн 20-ны өдрийн дотор тухайн шатны Засаг даргын Тамгын газарт хүргүүлж байна.

Гурав.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилан ялгах

3.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх

3.1.1.Тухайн сумын Засаг даргын захирамжаар сар бүр нийтийн эзэмшлийн гудамж, хуваарьт талбайн болон аж ахуйн нэгж байгууллага бүр орчны газрынхаа 50 метр талбайн хог хаягдал, цас мөсийг тогтмол цэвэрлэнэ.

3.1.2.Айл өрх бүр хашаа, байрны гадна орчноо тогтмол цэвэрлэж хогоо ангилан ялган ачуулж гудамж талбайг цэвэрлэж өнгө үзэмжийг сайжруулан засварлана.

3.2.Энгийн хог хаягдлыг ангилан ялгах

3.1.Хог хаягдлыг ангилах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.7 дахь заалтад заасныг ойлгоно.

3.2.Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр дараах байдлаар ангилна.

3.2.1.Орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг хамгийн багадаа дараах төрлөөр ангилна.

- а.Дахин боловсруулах боломжтой хог хаягдал
- б.Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал;
- в.Хүнсний органик хог хаягдал;

3.2.2.Гэр хорооны айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг хамгийн багадаа дараах төрлөөр ангилна.

- а.Дахин боловсруулах боломжтой хог хаягдал;
- б.Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал;
- в.Үнс буюу шаарга;
- г.Хүнсний органик хог хаягдал

3.2.3.Дахин ашиглах боломжтой хог хаягдалд дараах хог хаягдал хамаарна:

а.Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа/

б.Хуванцар /төрөл бүрийн ус,ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь,угаалгын шингэний хуванцар сав, гм/

в.Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс,гууль, тэдгээрээр хийсэн зүйл;

- г.Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/;
- д.Лааз;
- е.Мод, модон эдлэлийн хаягдал;
- ё.Хувцас, даавуун эдлэл;
- ж.Савхи, резин;
- з.Өвс, мод.

3.2.4.Хүнсний хог хаягдалд дараах хог хаягдал хамаарна:

- а.Хоолны үлдэгдэл;
- б.Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл;
- в.Яс;
- г.Хэрэглэсэн хүнсний тос;

3.2.5.Үнсэнд дараах хаягдал хамаарна:

- а.Өрхийн;
- б.Халаалтын болон нам даралтын зуух;
- в.Цахилгаан болон дулааны станцын зуух;

3.2.6.Бусад хог хаягдалд дараах хог хаягдал орно:

- а.Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдал;
- б.Байгаль орчинд сөрөг нөлөөгүй мал, амьтны сэг зэм, ургамлын хог хаягдал;

в.Барилгын болон тусгаарлах материалаас гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал;

г.Боловсруулсан дахин ашиглах боломжгүй бохир хөрс, шороо, чулуу, элс, хайрга;

д.Хаягдал халдваргүйжүүлэх төхөөрөмжөөс гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал, далан, усан сангийн лав /үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаар гарах лаваас бусад/;

е.Ахуйн болон үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний дахин ашиглах боломжгүй, аюулгүй хог хаягдал;

ё.Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал;

3.2.7.Энгийн хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав дараах шаардлагыг хангасан байна.

а.Хогийн сав нь Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагаас гадна шавж, мэрэгч, шувуу, амьтан орох боломжгүй хамгаалалт, хаалт, тагтай байна;

б.Ангиллын төрлийг заасан таних тэмдэг, өнгөтэй байна;

в.Хог хаягдлыг ангилж хийх, хадгалахад хялбар хийц загвартай, өнгө үзэмжтэй байна;

г.Хогийн савыг тогтмол цэвэрлэн, сард нэгээс доошгүй удаа ариутгана;

3.3.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ангилан ялгасан хог хаягдлаа зориулалтын дагуу Эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

3.3.1.Эрх бүхий этгээд ангилсан хог хаягдал тус бүрийг зориулалтын газар хүргэх ажлыг зохион байгуулна.

3.3.3.Иргэн, аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

Дөрөв.Энгийн хог хаягдлыг цуглуулах,тээвэрлэх

4.1.Энгийн хог хаягдлыг цуглуулах

4.1.1.Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

4.1.2.Хог хаягдлыг цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.

4.1.3.Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байрлуулна.

4.1.4.Хогийн сав байршуулах талбайн хөрсийг тэгшлэн нягтаршуулсан, зориулалтын хавтан дэвсгэр дэвссэн мөн тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зай талбайтай байна.

4.2.Энгийн хог хаягдлыг тээвэрлэх

4.2.1.Энгийн хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь

зориулалтын битүүмжлэлтэй, технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, задгай тэвштэй тээврийн хэрэгслээр тээвэрлэх бол хог хаягдал хийсэхгүй, асгахгүй байх нөхцөлийг хангасан байна.

а.Тээвэрлэх хог хаягдлын төрөл, ангиллыг заасан тэмдэг, тэмдэглэгээтэй;

б.Хотын өнгө үзэмжид нийцсэн цэвэрхэн, зориулалтын байх

в.Дуудлагаар хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж болох ба энэ талаар гэрээнд тодорхой тусгана.

г.Батлагдсан маршрут, хуваарийн дагуу тээвэрлэнэ.

д.Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл өмсөж, аюулгүй ажиллагааны шаардлага хангаж ажиллана.

е.Тээврийн хэрэгслийн жолооч нь Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг тухай хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, зохих ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох жолооны үнэмлэхтэй байна.

Тав.Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах

5.1.Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах

5.1.1.Хог хаягдлыг дараах байдлаар ашигласныг сэргээн ашиглах гэнэ.

а.Хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй технологиор, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зориулалтын байгууламж, тоног төхөөрөмжид зөвшөөрсөн газарт шатааж, эрчим хүч /цахилгаан, дулаан, халуун ус/ үйлдвэрлэх

б.Байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр, зөвшөөрсөн арга, технологиор хог хаягдлыг нэрэх, угаах, ариутгах, цэвэрлэх, сэргээх аргаар боловсруулж, эргүүлэн ашиглах чанарын шаардлага хангасан, эдийн засгийн хувьд ашигтай болгож хог хаягдлыг анхны хэлбэрт оруулах

в.Хог хаягдал сэргээн ашиглах технологи нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ашигласан бүтээгдэхүүн нь хүн, мал, амьтан, ургамалд хор хөнөөлгүй байна.

г.Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг шатааж, эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр барьж болох ба хог хаягдлыг тээвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх боломжгүй алслагдсан газар нутаг, суурин газарт өндөр даралт болон битүүмжлэл бүхий хог хаягдал шатаах зориулалтын, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, байгаль орчны холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн жижиг оврын хог хаягдал шатаах байгууламж ашиглан дулаан, халуун ус үйлдвэрлэж хог хаягдлыг сэргээн ашиглаж болно.

5.1.2.Хог хаягдлыг сэргээн ашиглах байгууламж нь Хог хаягдлын тухай хуулийн 17.1-д заасан ерөнхий шаардлагаас гадна дараах

шаардлагыг хангасан байна.

а.Байгууламж нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт технологи бүхий байна.

5.1.3.Хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагааны ажиллах хүчин нь Хог хаягдлын тухай хуулийн 16-д заасан ерөнхий шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

а.Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан;

б.Хог хаягдал дахин сэргээх байгууламжийн зорилго, үр дүнг тодорхойлох чадвартай, техник технологийг бүрэн эзэмшсэн.

5.2.Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах

5.2.1.Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь түүхий эд болох хог хаягдлыг өөрөө болон эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагаар дамжуулан цуглуулж болно.

5.2.2.Хог хаягдлыг дахин боловсруулах арга, технологи нь байгаль орчинд ээлтэй, орчин үеийн, хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт техник, технологи байна.

5.2.3.Дахин боловсруулах үйлдвэрээс гарсан шинэ бүтээгдэхүүн нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн мал, ургамал, амьтанд аюулгүй, хүний хэрэгцээ, шаардлагыг хангасан байна.

Зургаа.Энгийн хог хаягдлыг устгах, булшлах

6.1.Эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь сэргээн ашиглах, дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга технологиор устгаж булшилна.

6.2.Энгийн хог хаягдлыг устгах

6.2.1.Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор энгийн хог хаягдлыг устгахад дараах төрлийн үйл ажиллагаа хамаарна.

а.Хог хаягдлын төвлөрсөн цэгт эрх бүхий этгээд зориулалтын тоног төхөөрөмжөөр ландфилл аргаар газарт булшлах;

б.Химийн аргаар зарим төрлийн хог хаягдлыг урвалд оруулж, боловсруулж устгах;

в.Биологийн аргаар байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр боловсруулж устгах;

г.Зориулалтын байгууламжид байгальд ээлтэй технологиор хог хаягдлыг шатаах;

д.Хог хаягдлыг халдваргүйжүүлж, байгальд хоргүй болгож устгах;

6.3.Энгийн хог хаягдлыг булшлах

6.3.1.Хог хаягдлын төвлөрсөн цэгт эрх бүхий иргэн, аж ахуй

нэгж, байгууллага хог хаягдлыг зориулалтын тоног төхөөрөмжөөр ландфилл аргаар газарт булшлах.

6.3.2.Хог хаягдлыг булшлах үйл ажиллагаа нь дэлхийн эрүүл мэндийн болон байгаль орчны холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөмжийн дагуу байгаль орчинд хоргүй, нөхцөлөөр, ландфилл аргаар хийгдэнэ.

Долоо.Хүлээх үүрэг

7.1.Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг:

7.1.1.Журмын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох

7.1.2.Журмыг хэрэгжүүлэхэд сумдын Засаг дарга болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллах

7.1.3.Энгийн хог хаягдал булшлах, устгах үйл ажиллагаа эрхлэх байгууллагатай гэрээ байгуулах, зөвшөөрөл олгох

7.1.4.Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, булшлахад шаардагдах төсөв, техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

7.2.Сумдын Засаг даргын хүлээх үүрэг:

7.2.1.Сумын нутаг дэвсгэр дэх энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих, бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах

7.2.2.Сумын газар нутгийн онцлогоос хамаарч ангилсан хог хаягдлыг худалдан авах, түр хадгалах цэгийн байршлыг тогтоох

7.2.3.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-д заасан хэмжээгээр тооцож авахад хяналт тавих, үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх

7.2.4.Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, 9.4.14-д заасны дагуу хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллуулж, шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж батлуулах

7.2.5.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, иргэн аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах, сургалт зохион байгуулах

7.2.6.Хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах цэгийг байгуулах, хог хаягдлыг устгах булшлахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах.

7.2.7.Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх график, маршрутыг батлах, хяналт тавих.

7.2.8.Анхан шатанд ахуйн хог хаягдлыг ангилан ялгасан,

бусдад үлгэр дуурайл болсон айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, олон нийтэд сурталчлах.

7.2.9.Хог хаягдлыг бууруулах, төвлөрсөн цэгийг тохижуулах, устгах, булшлах үйл ажиллагаанд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын техник хэрэгслийг ашиглаж болно.

7.2.10.Эрүүл мэнд, барилга, хөдөө аж ахуйн, уул уурхай, зам тээвэр, батлан хамгаалахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудыг хог хаягдлаа тухайн чиглэлийн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан журмын дагуу цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлахыг шаардах, хяналт тавих.

7.2.11.Хог хаягдлын тайлан, мэдээг холбогдох иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас хугацаанд нь 6, 12 дугаар сарын 10-ны дотор Байгаль орчны газарт хүргүүлэх

7.3.Багийн Засаг даргын хүлээх үүрэг:

7.3.1.Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлыг багийн нутаг дэвсгэрт зохион байгуулах

7.3.2.Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах үйл ажиллагаанд хяналт тавих, иргэд аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдлыг бууруулах, ангилах, сэргээн ашиглах, дахин боловсруулах мэдээлэл, сургалтыг тогтмол зохион байгуулах.

7.3.3.Баг хороодод сайн дурын идэвхтэн ажиллуулах, хяналт тавих, дэмжин ажиллах

7.3.4.Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн аж ахуй нэгж байгууллагын тээвэрлэлтийн график, хугацаа давтамжид хяналт тавьж хамтран ажиллах

7.3.5.Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад гэр хороолол, СӨХ-тэй хамтран орон сууцны айл өрхийн иргэдийг татан оролцуулах.

7.3.6.Байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр үхсэн малын сэг зэмийн устгаж, хяналт тавьж ажиллах

7.3.7.Хог хаягдлын олон нийтийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

7.3.8.Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг ангилуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, бүртгэл хөтлөх;

7.3.9.Төвөөс алслагдсан хөдөөгийн айл өрхүүд өвөлжөө, хаваржаа, намаржаагаа тогтмол цэвэрлэх, нэгдсэн цэгт хаях зэрэгт хяналт тавих

7.4.Аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг:

7.4.1.Үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн

байгууллагууд хог хаягдал тээвэрлүүлэх гэрээг байгуулна.

7.4.2.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагад батлагдсан хуваарийн дагуу хүлээлгэн өгөх.

7.4.3.Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гаргах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлж үйлчилгээний хөлсийг хариуцах, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж эсхүл ажилтантай байх.

7.4.4.Эмнэлгийн болон барилгын хог хаягдлыг Барилга болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах.

7.4.5.Стандартын шаардлага хангасан ангилан ялгах хогийн савтай байх, шаардлагатай цэгт ангилан ялгах хогийн сав байршуулах.

7.4.6.Мэдээ, тайлан гаргах, хог хаягдлын тооллого судалгаатай байх, төсөв хөрөнгө төлөвлөх, нийтийг хамарсан цэвэрлэгээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;

7.5.Орон сууцны хорооллын айл өрхийн хүлээх үүрэг

7.5.1.Энгийн хог хаягдлаа ангилж дахин боловсруулах хог хаягдлаа эрх бүхий иргэн аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэн өгөх.

7.5.2.Энгийн болон дахин боловсруулах хог хаягдлыг орц болон зориулалтын бус цэгт хаясан айл өрхийг үнэн зөв баримттай мэдээлэх.

7.5.3.Нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцож нийтийн эзэмшлийн зам талбай болон орц, байрны ойр орчмыг цэвэрлэж байх.

7.6.Гэр хорооллын айл өрхийн хүлээх үүрэг

7.6.1.Хог хаягдлын 10 дугаар зүйлд заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг хэрэгжүүлэх

7.6.2.Эрүүл аюулгүй цэвэр орчинд амьдрах хог хаягдал хаяхгүй байхыг бусдад уриалах

7.6.3.Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях

7.6.4.Энгийн хог хаягдлаа энэхүү журмын 3.2.2-д заасны дагуу ангилж зориулалтын тагтай саванд хадгалах, батлагдсан хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэн өгч, хамтран ажиллах.

7.6.5.Нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцож, хашааны дотор болон гадна хэсгийн ойр орчмын гудамж талбайг цэвэрлэх.

Найм.Хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

8.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаанд

дараах этгээд хяналт тавина.

8.1.1.Сум, багийн Засаг дарга;

8.1.2.Эрх бүхий Улсын байцаагч, Экологийн цагдаа, байгаль
хамгаалагч;

8.2.Хариуцлага хүлээлгэх

8.2.1.Хог хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хууль,
бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
10/69 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт*

**НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ
ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ**

№	Аймаг	Хэмжих нэгж /м2/	Үнийн тариф /төг/
1	2	3	4
1	Баянхонгор	1	9500

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Аймаг	Хэмжих нэгж /тн/	Үнийн тариф /төг/
1	2	3	4
1	Баянхонгор	1	12500

АРХАНГАЙ АЙМАГ ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 32

Баянцагаан

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.15 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит долдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Малын тоо толгойн албан татварын жилд ногдуулах хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Татварыг тогтоосон хувь хэмжээгээр холбогдох хууль, журамд заасны дагуу сумын Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, баг бүрээс төвлөрсөн орлогыг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт болон Татварын Ерөнхий газрын даргын 2021 оны А/09 дүгээр тушаалаар баталсан “Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам”-д нийцүүлэн зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагч буюу сумын Засаг дарга (С.Адъяасүрэн), Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга (Э.Мөнхзаяа), Татварын улсын байцаагч (Б.Пүрэвдорж) нарт үүрэг болгосугай.

3.Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон энэхүү тогтоолыг малчид иргэд, татвар төлөгчдөд сурталчилж ажиллахыг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчид, малын тоо толгойн албан татвар хураах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллагууд, нийт ажилтан, албан хаагчид, иргэдэд уриалсугай.

4.Уг тогтоол буюу захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

5.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн “Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Э.ГҮРРАГЧАА

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 сарын 18-ны өдрийн
32 дугаар тогтоолын хавсралт*

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Малын төрөл	Хэмжих нэгж (хугацаа)	Хэмжээ (Төгрөгөөр)
1	Хонь	1 жилд	300
2	Ямаа	1 жилд	300
3	Үхэр	1 жилд	300
4	Адуу	1 жилд	300
5	Тэмээ	1 жилд	0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 7542 дугаарт бүртгэв.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 7/17

Баян-Овоо сум

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын нийт өрх, аж ахуй нэгж, үйлдвэр үйлчилгээний газрууд, албан байгууллагуудын мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тогтоолыг зохих хууль журмын дагуу холбогдох газарт бүртгүүлж, үйлчилгээний хураамжийг дагаж мөрдүүлэн, хураамжийг бүрэн төвлөрүүлж ажиллахыг сумын Засаг дарга (О.Оргилсайхан)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 6/6 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.СОНИНБАЯР

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
7/17 дугаар тогтоолын хавсралт*

**ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ
ТОГТООХ ТУХАЙ**

№	Үйл ажиллагааны чиглэл	Төлбөр төлөх хугацаа	Төлбөр хураамжийн хэмжээ
1	Сумын төвийн айл өрх	03, 04, 05, 06, 07, 08, 09 дүгээр сард	5000
		10, 11, 12, 01, 02 дугаар сард	10.000
2	Төсөвт байгууллага	Сар бүр	30.000
3	Авто зам барилга угсралт, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж	Сар бүр	300.000
4	Үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, Хүнс барааны дэлгүүр, Архины зөвшөөрөлтэй дэлгүүр, Эмийн сан, Зочид буудал, Хоолны газар, Үсчин, Гутал засвар, Авто засвар, Дугуй засвар Бусад үйлчилгээний бүх байгууллага	Сар бүр	40.000
5	Эрчим хүч, дулаан хангамжийн байгууллага	Халаалтын улирлын хугацаа /10, 11, 12, 01, 02, 03, 04 дүгээр саруудад/	300.000

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авсан.*

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 03

Баян-Агт сум

ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалт, 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай” 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн III/01 дугаар тогтоол, “Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай” 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн VIII/06 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

2.Энэхүү тогтоолыг холбогдох газарт хүргүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (М.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.БАТМАГНАЙ

АРХАНГАЙ АЙМАГ ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 03/08

Хөшөөт

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын Тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Малын Тоо Толгойн Албан Татварын Тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг Тэмээ 0 төгрөг, адуу 0 төгрөг үхэр 0 төгрөг, хонь 0 төгрөг, ямаа 0 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол болон бусад холбогдох бичиг баримтын бүрдэлийг хангаж Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Засаг дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай 50 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Х.БҮРЭНБААТАР

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 2 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авсан.*

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар А/13

Улаанбаатар
хот

ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛОХ ТУХАЙ

Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.13, 17.14, 17.15 дахь заалтыг хэрэгжүүлэх, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Бүтэц, дүрэм батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/593 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл”-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.5, 4.6.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын ерөнхий хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай” А/593 дугаар тушаал гарсантай холбогдуулан хавсралтад заасан эрх зүйн зохицуулалтгүй болсон Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөлийн тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн даргад даалгасугай.

ЗАХИРАЛ

Б.АМАРСАНАА

2026 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт

**ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТААС ХАСУУЛАХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ
БИЧГИЙН ЖАГСААЛТ**

Захиргааны хэм хэмжээний актын нэршил	Хэм хэмжээний актын хавсралтаар батлагдсан шаардлага	Хэм хэмжээний актад бүртгэгдсэн хугацаа, дугаар
2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөлийн №06 тогтоол”	Докторын ХМИ шалгуур шаардлага Докторын ХУМИ шалгуур шаардлага Магистрын ХМИ шалгуур шаардлага Дээд боловсролын сургалтын байгууллагыг МИ шалгуур шаардлага	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 4789 дүгээрт бүртгэв. ЗХХАЭ-ийн 2020 оны 15 дугаарт нийтлэгдсэн.
2019 оны 9 дүгээр сарын 25-ний өдрийн Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөлийн №05 тогтоол	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 4491 дүгээрт бүртгэсэн.
2016 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдах зөвлөлийн №001 дугаар тогтоол	Мэргэжлийн боловсрол сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 4368 дугаарт бүртгэсэн.
Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 281 тогтоол	Боловсролын магадлан итгэмжлэх байгуулын дүрэм	

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авсан.*

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 2 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар А/75

Улаанбаатар
хот

ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгалийн ургамлын тухай хуулийн 7¹ дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зарим зүйл нэн ховор, ховор, элбэг ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг хавсралт ёсоор баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар /Ц.Уранчимэг/-т даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/603 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ОДОНТУЯА

